



**ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
БҮСИЙН ОНОШИЛГОО, ЭМЧИЛГЭЭНИЙ
ТӨВИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2024 оны 03 сарын 11 өдөр

Дугаар А/10

Арвайхээр

г Үнэлгээний хороо байгуулах тухай 1

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.2, 50 дугаар зүйлийн 50.1 дэх заалт, Захиргааны ерөнхий хуулийн 43, 46 дугаар зүйлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Тус төвд 2024 онд шаардлагатай урсгал засварын материал (Барилга, тоног төхөөрөмж, автомашин) нийлүүлэх тендерийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга:Д.Наранхүү (Аж ахуй албаны дарга)

Нарийн бичиг:Э.Түмэнжаргал (Эдийн засагч)

Гишүүд:Д.Аззаяа (Гүйцэтгэлийн удирдлага дотоод хяналтын албаны дарга)

Б.Цэвэлмаа (Тоног төхөөрөмжийн инженер)

Г.Гантөмөр (Оновчтой хөгжил ТББ)

2.Худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, мэдэгдэл, гэрээний төслийг өргөн мэдүүлэхийг Үнэлгээний хороо (Д.Наранхүү)-д даалгасугай.

3.Тендер шалгаруулалттай холбоотой баримт бичгээр хууль тогтоомжийн дагуу архивын нэгж бүрдүүлж, Архив, бичиг хэргийн ажилтанд хүлээлгэн өгөхийг Үнэлгээний хорооны нарийн бичиг (Э.Түмэнжаргал)-д үүрэг болгосугай.

ЗАХИРАЛ  Г.ДАШЖАНЦАН

